

Хэсэг 8

Монголын Сүсэгтний холбооны үйл ажиллагаа бурханы шашны хөгжилд оруулсан хувь нэмэр

Сандагийн Баянцагаан

Редакторын тайлбар: Монголын бурханы шашны хөгжлийн төлөө зүтгэгчдийн дотор чин сүсэгтэн С.Баянцагаан гуай хичээл зүтгэлтэй, даруу төлөв байдлаараа ялгардаг билээ. Тэрээр өөрийн хийд, бясалгалын төвийг Тэрэлжийн хөндийд байгуулж бурхдын томоохон хөрөг дүрийг зурж бүтээсэн ба мөн Монголын Сүсэгтний Холбоог тэргүүлэн ажиллаж байв. Социализмын үед нурж сүйдсэн 2500 орчим сүм хийдийг сэргээх ажиллагаа хэчнээн чухал болохыг тэрбээр ойлгож, энэ үйл хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулсан байна. Энэхүү эмхэтгэлд тэрээр Монголын бурханы шашны сэргэлтийг тоймлон олон санаачилга, үйл ажиллагааг үнэлж мөн тулгарч буй бэрхшээлийг зоригтой дурдаж өгүүлсэн байна. С.Баянцагааны шашны хөгжил, иргэний эрх чөлөө, ялангуяа өнгөрсөн хэлмэгдүүлэлтэнд хандаж буй хүлээцтэй байдлыг онцлон дурдах нь зүйтэй билээ. Тэрбээр өнөөгийн Монголын бурханы шашны хөгжилд Сүсэгтний холбооны оруулсан найман хувь нэмэр болон тулгарч буй сорилт, бэрхшээлийг үнэлж, тэнцвэртэй, уялдаа холбоотойгоор энд танилцуулж байна.

Монголын ардчилсан хувьсгалын хамгийн том ололт нь оюун санаа, шашин шүтлэгийн эрх чөлөөг авчирсан явдал юм. 1990 оны 3 дугаар сард Монголын Сүсэгтний холбоо байгуулагдаж даруй ард түмний дийлэнхи олонхийн дэмжлэг авч эхэлсэн билээ. Холбооны салбар зөвлөлүүд бүх аймгууд болон дийлэнхи сумдад байгуулагдсан нь цаашид нийт улс орон даяар идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлсэн

юм. Монголын Сүсэгтний холбоо их хурлаа хуралдуулж, мөрийн хөтөлбөрөө баталсан нь тус холбоо 8 жилийн турш нийгэм, сүсэгтэн олны дунд идэвхтэй үйл ажиллагааг явуулах, улмаар орчин үеийн Монголчуудын шашныг үзэх итгэл үнэмшилд өөрчлөлт хийх үндсэн баримт бичиг болсон. Ийнхүү Монголын Сүсэгтний холбоо байгуулагдаж өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах боломж тохироо бүрдснийг доорх шалтгаан, нөхцлүүдээр тайлбарлах саналтай байна.

Үүнд:

1. Коммунист ёс халагдаж, ардчилал, эрх чөлөөг бий болгосон түүхэн цаг үетэй давхцсан;
2. Ингэснээр шашны эрх чөлөөгөө эдлэхийг хүссэн сүсэгтэн олны хүсэлт бий болсон;
3. Хувьсгалт өөрчлөлтийг дэмжин талархаж байсан бусад улс орнууд болон бурханы шашны тэргүүн Далай ламын дэмжлэгт зоригжсон;
4. Сүм хийдүүдийг сэргээн хурал номын үйл ажиллагааг эхлүүлэхэд ном эрдэмтэй өвгөдийн залгамж халаа орон нутагт арай тасраагүй байсан;
5. Бурханы шашны уламжлал тасарсан ч шинэ нөхцөл байдалд сэргэх нь дөхөм хурдтай байсан;
6. Хаалттай, хориотой цагийн зовлон эдэлж байсан ард түмэн ардчилал, эрх чөлөөг амсаж баярлаж бахдаж байсан үе;
7. Тэр үест бурханы шашныг зүй ёсоор нь сэргээхийн төлөө хүн бүр чин сэтгэлээсээ хүсэн тэмцэж, өглөг буяны давалгаа хүчтэй, хармын сэтгэлгүй байсанд
8. Харь шашны нөлөө бараг үгүй байсан зэрэг нөхцөл бүрдсэн байв.

Бурханы шашны дахин сэргэхэд тулгарсан бэрхшээл

Монголын Сүсэгтний холбоог үүсгэн байгуулж удирдаж байсан миний хувьд болон ер нь тэр үед шашны төлөө хэмээн тэмцэж зүтгэж байсан хүмүүсийн хувьд мэдэхгүйн

зовлон их байсныг энд тэмдэглэе. Мөн түүнчлэн коммунист үзэл суртлын хүч бага зэрэг суларсан ч гэлээ амь бөхтэй оршоор байсан, ялангуяа хөдөө орон нутагт энэ бэрхшээл илүү мэдрэгдэж байв. Бүхэл бүтэн хоёр үе шашингүйн онол, үзэл суртал, соёл урлагаар хордсон байсан тул эргэлзэн тээнэгэлзэх үзэл бодол амь бөхтэй байсаар байв. Гэхдээ энэ нь бидний ажилд төдийлөн саад болж чадаагүй бөгөөд харин ч хүчээ нэгтгэн зохион байгуулалтанд орж ажиллах боломжийг олгосон. Шинээр сэргэсэн хурал хийдэд шашны эдлэл хэрэглэгдэхүүн ном судар олдохгүй байсан нь мөн томоохон бэрхшээлүүдийн нэг байв. Уламжлал тасарсан тул бурханы шашныг жаяг ёс алдагдаж үлгэрлэн дагуулах лам хувраг, сүм хийд байсангүй. Социализмын үед Монголд цор ганц Гандан хийд үйл ажиллагаагаа хязгаарлагдмал хүрээнд явуулж байсан юм.

Монголын Сүсэгтний Холбооны дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр ямар үр дүнд хүрснийг танилцуулах явцад бидний бодлого, үйл ажиллагаа юунд чиглэгдэж байсныг та бүхэн ойлгох буй заа.

1. 1990-ээд оны эхнээс Монголын ард түмэн ардчилсан, олон ургальч үзлийг хүлээн авч, шашин номыг үзэх, сүсэглэх эрх чөлөөтэй болсон нь Монголын Сүсэгтний Холбоо үйл ажиллагаа явуулж, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломжийг бий болгосон.
2. Дээдсээс өвлөгдөн ирж, хэдэн зууны туршид соёл, заншилд шингэсэн бурханы шашны үзэл онолыг хэдүй нухчин дарж, лам хувраг нарыг хэлмэгдүүлсэн ч дахин сэргэнэ гэсэн найдлага горилын галыг тээсэн нэгэн үеийн хүмүүс амьд сэрүүн байсан нь шашин зан үйл сэргэхэд голлох хүчин болсон юм. Тэд бидэнд шашин номын галыг бадраах ариун үйлсийг өвлүүлэн үлдээсэн гавьяатнууд билээ.
3. Монголын сүсэгтэн олонд шашин ном дахин сэргэх

сэтгэл итгэлийн гал байсан тул тэр их сүжгийн хүч Монгол орон даяар өрнөж, Монголын Сүсэгтний Холбооны зохион байгуулалт, удирдлагаар 1930-40-өөд онд байсан 700 гаруй сүм хийдийн ор туурин дээр 1993 он гэхэд 70 гаруй сүм хийдийг сэргээж үйл ажиллагаанд нь оруулсан. Энэ үед лам хуврагийн тоо 1000 гаруйд хүрч байв.

4. 1991 онд Монголын Сүсэгтний холбооны удирдлага, санаачилгаар анхны шашны дунд сургууль байгуулагдаж, сүм хийдийг шашны боловсрол мэдлэгтэй лам хувраг, боловсон хүчнээр хангах их үйлс эхлэж одоо хэр нь тасралтгүй үргэлжилсээр байна.
5. Монголын нийт сүсэгтэн олонд бурханы шашны гүн ухаан, шашны хэргийн мэдлэг олгоход мөн анхаарлаа хандуулж ажилласан. Үүнд бүх аймаг сумдад МСХ-ы салбар холбоо, зөвлөлийг байгуулж тэрхүү сум, багийн салбар зөвлөлөөр дамжуулан сүсэгтэн олны чин сүжиг итгэл үнэмшлийг улам хөгжүүлэхийн тулд өөрийн мөрийн хөтөлбөрөө таниулан, улмаар шашин гүн ухааны чиглэл сэдвээр яриа таниулга тогтмол хийж ирсэн нь их нөлөөтэй ажил болсон хэмээн үздэг.
6. МСХ Улаанбаатар хотод Ламрим дацанг байгуулж, түүнийг түшиглэн бурханы шашны гүн ухаан, хурал уншлагын ном бүтээл хэвлэх барханы газар ажиллуулан айл бүхэнд Алтангэрэл, Сандуйн жүд номыг хүртээхийг зорьсон.
7. Мөрийн хөтөлбөрийн дагуу байгаль орчныг хамгаалах боломжит ажлыг хийж ирснээс уламжлалт шүтлэгтэй овоо, хайрханыг тахиx ёс зан үйлийг өөрийн салбар холбоо, зөвлөлөөр дамжуулан зохих заавар удирдамжийн дагуу гүйцэтгэх ажлыг эхлүүлж уламжлал болгов. Өргөн олныг хамарсан томоохон овооны тахилгыг Баянзүрх хайрхнаас эхэлж залуу хойч үеийг газар дэлхий савдаг шивдэгийн эзэнлэг үүднээс

хандаж хайр гамтай, хүндлэл бишрэлээр хандахад хувь нэмэр оруулсан юм.

8. Монголын улс төрд үгүүлэгдэж буй шашны байр суурийг тодорхойлохыг зорьж, Монголын шашинтны ардчилсан намыг байгуулж үйл ажиллагаанд оруулсан зэрэг тал бүрийн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн билээ.

Бурханы шашны цаашдын хөгжилд учирч буй бэрхшээлийг даван туулах талаар

1. Бурханы шашин өөрийн дотоод бүтэц нарийн дэг, ёс жаягаар гол болгон хөгжил цэцэглэлтэнд хүрдэг билээ. Гэтэл энэ нандин уламжлал ёс горим өнөө энэ үед бараг үгүй болж бурханы шашин гэдэг маань сайн дурын, дур зоргын хэрэг болсныг бид бэлхэнээ харж байна. Үүний тод жишээ нь лам хувраг нар ердийн амьдралаар аж төрөх, хашаа, байр, гэр орноо дур зоргоор бурханы шашны сүм орон болгох, шашны жаяг ёсонд чандлан хорьсон мэргэ төлөг, үзмэр зурхайгаар сүсэгтэн олныг илтээр мунхруулах, элдэв өргөл барьж авах зэрэг ёс зүйгүй элдэв үйлдэл олон гарч байна. Энэ нь бурханы шашныг амьдрах, аж төрлөө дээшлүүлэх нэгэн хэрэгсэл болгосны тод жишээ мөн. Энэ нь ард олныг бурханы шашны хэргийн мэдлэг дутмаг, мухар сүсэгт хэт автсан төлөв байдлыг нь ашиглаж буй дорой арга юм. Социализмаас өмнө бурханы шашин нар мэт мандаж байсан сайн цагт, чин сүсэгт сүжигтэн олон түмний хурц хараа хяналтан дор, ёсгүй, шашин, номд цөв суух элдэв харш үзэгдэлтэй тэмцэж, хянан зохицуулж байсныг түүх гэрчилдэг. МСХ өөрийн үйл ажиллагаа, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлсэн үест төрөөс шашин шүтэх, эс шүтэх эрхийн тухай хууль гарсан бөгөөд энэ нь олон талаар учир дутагдалтай хууль болсон.
2. Бурханы шашин ариун ёс журмаар явж замнах ёстой. Лам хуврагууд гэж хэн бэ? гэдэг асуулт өнөөгийн бидний хувьд маш чухал асуудал болон тавигдаж буй

бөгөөд энэ нь цаашлаад Монгол оронд өнөө цаг үед бурханы шашин оршин тогтнож буй эсэхэд хүрэх эмзэг асуудал болж байна. Бурханы шашны сургаал номлол ёсоор лам хувраг нар винайн (Vinaya) ёсыг хэрхэн баримталж буй нь бурханы шашин тогтож буй эсэхийг тодорхойлох хүчин зүйлийн нэг байдаг. Винайн 253 сахил, горимыг өөрийн амьдралдаа мөрдлөг болгодог гэлэнгийн сахилтай хүмүүн цөөн, харин гэнин сахилтай лам хуврагуудын тоо олон байна. Гэнин сахилыг эгэл хар хүмүүс ч авч сахидаг. Гэвч эдүгээ лам хуврагууд гэнин сахилаа ч ёс журмаар нь сахиж буй нь бас цөөхөн байна. Нэгэнт ийм нарийн дэг ёстой бурханы шашинтан лам хуврагийн дагаж мөрдөх жаяг ёс байсаар байхад түүнийгээ сахиж мөрдөхгүй байгаа нь бурханы шашныг үнэ цэнэгүй үлгэр дууриалалгүй болгож буй байна.

3. Өнөөгийн Монголын бурханы шашны боловсон хүчин буюу лам хувраг нарыг бэлтгэн сургах тал дээрх бодлогоо улам хөгжүүлэх хэрэгтэй байна. Үдээс өмнө энгийн хар хувцсаа өмсөж лам хувраг байснаа үдээс хойш энгийн хар хүний амьдралд шилжэх байдал түгээмэл байна. Тэдгээрт бурханы шашны жаяг ёс, дэглэм журам, тогтсон таалал, багш шавийн нарийн барилдлага ёс горимыг хэлж ярих, хүн үгүй, ялангуяа хөдөө орон нутагт ихэнхи шавь нар таамаг төдий явж байна. Хувраг бологсдод шашны болон иргэний боловсролын шалгуур тогтоох нь чухал байна.
4. Өнөөгийн Монголын бурханы шашныг хөгжилд учирч буй дараагийн нэгэн бэрхшээл бол бодлогын нэгдсэн хөтөлбөр үгүй, сүм хийдүүд салангид тусдаа үйл ажиллагаагаа явуулж буй явдал юм. Монголын бурханы шашны сүм хийд байгууллагууд нийгмийн хөгжил хийгээд хамаг амьтны тусын тулд хамтран

ажиллах нь зүйтэй билээ. МСХ-ы үйл ажиллагааны үр дүнд 1990 оноос хойш бурханы шашин ба сүсэгтний харилцаа хөгжиж улмаар 70 гаруй сүм хийдийн үйл ажиллагааг сэргээж чадсан. Энэ үйл ажиллагаанд ихээхэн хүч чармайлт тавин оролцож зүтгэсэн иргэд, сүсэгтэн олны хувь нэмрийг байнга санаж байх нь зүйтэй билээ.

5. Олон шашин зэрэгцэн орших ардчилсан улсад амьдарч буйн хувьд бурханы шашинтнууд бусад шашны сүм, цуглаан бүлгийн үйл ажиллагааг шинжлэн судалж, нийгэмд тустай зүйл дээр хамтран ажиллах шаардлагатай. Шашнуудын талаарх цогц мэдээллийн сантай болж нийгмийн хөгжлийн сайн сайхны зүгт үйл ажиллагаа явуулдаг байх хэрэгтэй байна. Мөн олон нийтийн байгууллагуудтай ч хамтран ажиллаж, сайн сайхан ирээдүйн төлөө их зүйл хийхийг лам хувраг санваартнуудаас нийгэм олон хүлээж байна.
6. Бурханы шашинтны төв Гандантэгчилэн хийдийн үйл ажиллагаанаас бусад олон хийд орон сургамж авч цаашдын хөгжилдөө үлгэр авч байх ёстой билээ. Гэтэл өнөөгийн бурханы шашны төв ажин түжин суугааг юугаар ч зөвтгөхийн аргагүй юм. Бурханы шашны хөгжлийг шинэ шатанд гаргахад Монголын бүх сүм хийдүүд хамтын ажиллагааны цогц нэгдсэн хөтөлбөртэй байж, түүнээ жил бүр дүгнэн цэгнэж, нэгдсэн их хурлаар бурханы шашинд тус нэмэр үзүүлэх удирдлагыг сонгож байх хэрэгтэй байна.
7. Өнөөгийн бурханы шашны сүм хийдүүдийн үйл ажиллагаа зөвхөн хурал уншлага, гүрэм дором, сүсэгтний захиалгат зан үйлээр хязгаарлагдаж байна. Бурханы шашин цэцэглэн хөгжих олон шат, түвшин байдаг. Үүнд бурханы шашны түүх, гүн ухаан, сургаал номлолыг судлах, сүсэгтэн олон өдөр тутмын амьдрал

ахуйдаа хэвшүүлэн дадуулах, тэдэнд зориулагдсан бүтээл бясалгалын хичээл, сургалтыг зохион байгуулах зэрэг болно.

8. Өнөөгийн Монголын сүм хийд зөвхөн сүсэгтний өргөсөн хандивын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал эдийн засагтай байна. Мөн бурханы шашны сүм хийд, дуган барих стандартыг боловсруулж хэв хэлбэр, өнгө архитектурын шийдлийг хөгжүүлэх шаардлагатай байгаа билээ.